



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/308

Алтай хот

Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө  
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир уулын аймаг байгуулагдсан түүхт 100 жилийн ойг угтаж, Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг өсвөр үе, хүүхэд залуучуудад таниулах, тусгаар тогтнол, үндэсний эв нэгдэл, эрх чөлөө, түүний үнэ цэнийг ойлгуулах, эх орон, байгаль, түүх соёлоо хайрлан хамгаалах, эх оронч иргэний үзлийг төлөвшүүлэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн байлдааны тугийг аялуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Мэндбаяр	(Цагдаагийн газрын дарга)
Гишүүн:	Б.Золжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д.Төмөрбаатар	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
	Ц.Лувсанжамц	(Онцгой байдлын газрын дарга)
	Г.Ганбат	(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга)
	О.Лхагвасүрэн	(Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтсийн дарга)
	Ж.Энхбаяр	(Шүүхийн шинжилгээний хэлтсийн дарга)


2.

Нарийн бичгийн дарга:Б.Мягмарсүрэн (Цагдаагийн газрын Захиргаа,  
удирдлагын хэлтсийн дарга)

2.Тус үйл ажиллагаанд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Ажлыг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсэг (Д.Мэндбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР